



**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2009 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

**ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", 29.1.6—ын "л", 29.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэр, Улсын Онцгой комиссын 2009 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 593 дугаар захирамжийг үндэслэн **ТУШААХ НЬ**:

Нэг. Нийслэлийн нутаг дэвсгэрт Олон улсын дүрмээр зохицуулагдах халдварт өвчин болох А хүрээний H1N1 вирусээр үүсгэгдсэн халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээг 2009 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаагаар зогсоосугай.

Хоёр. Өөрийн байгууллага дээрээ ариутгал, халдвартгүйтгэлийн ажлыг зохион байгуулж, ажилтнуудыг халдвараас сэргийлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг ахлах мэргэжилтэн /А.Болдмаа/, дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодын дарга наарт үүрэг болгосугай.

Гурав. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж, ажлын тайланг 7 хоног бүр гаргаж тайллагнахыг дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодын дарга наарт даалгасугай.



Ж.ГАНБОЛД